



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

 |

2020 ОН

*Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин,
стандартын шинэтгэлийн жил*

**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
БҮЛЭГ 1. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	4
Бүтэц, зохион байгуулалт	4
Аудитын үйл ажиллагаа	5
БҮЛЭГ 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	8
Санхүүгийн тайлангийн аудитын үр дүн	9
Санхүүгийн тайлангийн аудитын үр нөлөө	11
ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудит	12
ТЕЗ-ийн 2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	12
БҮЛЭГ 3. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ	13
Гүйцэтгэлийн аудитын үр дүн	13
Гүйцэтгэлийн аудитын үр нөлөө	14
Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг	15
Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн боловсролын болон их дээд сургуулиудын үйл ажиллагааны үр дүн	15
Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах	16
Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл	17
Төрөөс бүх нийтийн боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн	17
БҮЛЭГ 4. НИЙЦЛИЙН АУДИТ	18
Нийцлийн аудитын үр дүн	19
Нийцлийн аудитын үр нөлөө	19
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих тухай хууль тогтоомжийн хэрэгжилт	21
Орон нутгийн ээлжит сонгуульд оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн улс төрийн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, эдийн засгийн тооцоо судалгаанд дүгнэлт гаргах	21
Орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох	22
Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүнг нийтэд мэдээлэх	22
Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулах, дүгнэлт гаргах	23
Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт	23
Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт	24
БҮЛЭГ 5. ИТХ-ЫН ХҮСЭЛТЭЭР БОЛОН ӨӨРИЙН САНААЧИЛГААР ХИЙСЭН АУДИТ	25
БҮЛЭГ 6. ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ	25

БҮЛЭГ 7. ДОТООД АЖИЛ	26
Дотоод сургалт	26
ҮАГ-аас хийсэн сургалт	27
Бусад сургалт	28
Хамтын ажиллагаа	28
Мэдээлэл сурталчилгаа	29
Албан харилцаа	30
Өргөдөл гомдол	31
Шагнал урамшуулал	31
Нууцын хадгалалт, хамгаалалт	32
Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх	33
Цаг үеийн шинжтэй гүйцэтгэсэн нэмэлт ажлууд	33
Мэдээллийн технологи	
Үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн шинэлэг ажлууд	35
БҮЛЭГ 8. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	37
БҮЛЭГ 9. ДҮГНЭЛТ, ЦААШДЫН ЗОРИЛТ	39

Товчилсон үгийн тайлбар

МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
ТАБ	Төрийн аудитын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТАГ	Төрийн аудитын газар
ААН	Аж ахуйн нэгж
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУ	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТА	Тэргүүлэх аудитор
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
УИХ	Монгол Улсын их хурал
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ЗГ	Засгийн газар
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
ТГ	Тамгын газар
НАГ	Нийцлийн аудитын газар
МНБ	Мэргэшсэн нягтлан бодогч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТВ	Телевиз
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТБОНӨААН	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
АТГ	Авлигатай тэмцэх газар
ГХЗУСТ	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
МТ	Мэдээллийн технологи
НАНБХАСЗАСЗУСТ	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогыг мэдүүлэг
ХШҮДАГ	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
НД	Нийгмийн даатгал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

1. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар нь 2020 онд ТАБ-ын хэмжээнд дэвшүүлсэн “Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн жил”-ийн хүрээнд Газрын 2020 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан МУЕА-ын орлогчоор батлуулан ажиллалаа.


Төлөвлөгөөг “Төрийн аудитын байгууллагын 2019-2024 онд хэрэгжүүлэх стратеги” болон УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2019 оны аудитын сэдэв батлах тухай 05, 2020 оны 04 дүгээр тогтоолууд, МУЕА-ын 2019 оны А/100, 2020 оны А/53 дугаар тушаалуудаар батлагдсан “Нийслэл, аймаг дахь ТАГ-уудын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, ТАБ-ын Гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн боловсрууллаа.

Газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан аудит болон дотоод үйл ажиллагаатай холбоотой ажлуудыг бүрэн хэрэгжүүллээ.

Бүтэц, зохион байгуулалт


МУЕА-ын баталсан бүтэц, орон тооны дагуу 12 албан хаагч, санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудит болон нийтлэг үйлчилгээний албадын зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулсан.

Схем №1. “Газрын бүтэц, зохион байгуулалт”




Хүний нөөц


Ажилласан жилээр:




Насны бүтцээр:



Мэргэжил, мэргэшил:



Боловсролын зэрэг:



Төрийн аудитын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр:



- Хөдөлмөрийн дотоод журмын дагуу 8 ажилтанд 14 өдрийн цалинтай чөлөө
- Цар тахлаас сэргийлэх, албан хаагчдын дархлааг сайжруулахад 2,987.0 мянган төгрөгийн дэмжлэг
- Түлээ нүүрсний хөнгөлөлтийг 2 албан хаагчид 236.0 мянган төгрөгөөр
- Хорио цээрийн дэглэмийн үед хүүхдээ асрахад зориулж ажлын цагийг богиносгох
- Албан хаагчдын гэр бүлийг дэмжих зорилгоор 650.0 мянган төгрөгийн дэмжлэг
- Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилгоор аудитын эрх олгох сургалтад хамрагдсан 2 албан хаагч болон мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхээ авсан албан хаагчид нийт 1,000.0 мянган төгрөгийн дэмжлэг
- 2020 оны ажлын бүтээмж, үр дүнгээрээ тэргүүлсэн албадын албан хаагчдад 2,100.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал олгосон.



Ахмад ажилтнуудад 1,132.0 мянган төгрөгийн тэтгэмж

Аудитын үйл ажиллагаа

Төрийн аудитын газар нь 2020 оны эхний хагас жилийн байдлаар 176 аудитыг гүйцэтгэж, үүнээс Санхүүгийн тайлангийн аудитаар орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бүх шатны төсөв захирагчдын төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайланд 164 бие даасан дүгнэлт гаргасан байна. Гүйцэтгэлийн 5 аудитад 72, нийцлийн 7 аудитад 290 байгууллага, нэгжийн үйл ажиллагааг тус тус хамруулсан байна. (Дүрслэл 1)

Дүрслэл 1. Гүйцэтгэсэн аудит



Дүрслэл 2. Аудитын илрүүлэлт



Нийт гүйцэтгэсэн аудитын дүнгээр 43.2 тэрбум төгрөгийн 578 алдаа, зөрчил илрүүлж (Дүрслэл 2), тэдгээрийн 13.3 хувь буюу 5.7 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, нийт 5.8 тэрбум төгрөгийн зөрчилд 81 төлбөрийн акт тогтоож, 23.6 тэрбум төгрөгийн 179 албан шаардлага, 8.0 тэрбум төгрөгийн 233 зөвлөмж, 57.7 сая төгрөгийн 8 хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн байна.



Санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэл, нийцлийн аудитын 5 жилийн харьцуулсан гүйцэтгэлийн үзүүлэлтийг харууллаа.

Дүрслэл 3. “Гүйцэтгэсэн аудит (тоон харьцуулалт)”




Төрийн аудитын газар нь 2020 оны жилийн эцсийн байдлаар улс, орон нутгийн төсөвт 282.1 сая төгрөгийг төвлөрүүлж, нийт 11,831.4 сая төгрөгийн үр өгөөжийг аудитад хамрагдсан байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн нь төсвөөс авсан санхүүжилтийн 1 төгрөг тутамд 30.2 төгрөгийн үр өгөөжийг бий болгосон байна.

Дүрслэл 4. Аудитын үр нөлөө



Аудитын илрүүлэлтийн 10,871.6 сая төгрөг буюу 25.2 хувийг нягтлан бодох бүртгэл, тайлагналтай, 10,553.4 сая төгрөг буюу 24.4 хувийг төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй, 14,217.9 сая төгрөг буюу 32.9 хувийг хууль тогтоомжийн хэрэгжилттэй, 2,418.1 сая төгрөг буюу 5.6 хувийг худалдан авалттай, 2,120.8 сая төгрөг буюу 4.9 хувийг дотоод хяналт, хариуцлагатай, 1,664.7 сая төгрөг буюу 3.9 хувийг арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй, 1342.0 сая төгрөг буюу 3.1 хувийг бусад асуудалтай холбоотой зөрчил эзэлж байна.

Дүрслэл 5. Аудитын илрүүлэлт, алдаа зөрчлийн ангилал




Төлбөрийн акт: Тайлант хугацаанд 5,793.8 сая төгрөгийн 81 төлбөрийн акт тогтоосон нь өмнөх онтой харьцуулахад 17 дахин өссөн үзүүлэлттэй байна. Шалтгаан нь гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн ААН-үүдэд хийсэн гадаадаас ажиллах хүч авч ажиллуулах квотын аудит нөлөөлж байна. Тогтоосон актаас 201.9 сая төгрөгийг барагдуулж, өмнөх оны үлдэгдэл 179.7 сая төгрөгөөс 80.2 сая төгрөг нь барагдаж, 11.0 сая төгрөгийн акт хүчингүй болж хасагдаж, нийт 5,680.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс 5,580.9 сая төгрөгийн актын төлөгдөх хугацаа болоогүй байна. (Дүрслэл 6)


Албан шаардлага: Тайлант хугацаанд 23,566.9 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 2 дахин өссөн үзүүлэлттэй байна. Хэрэгжилтийн хувьд тухайн оны 23,343.0 сая төгрөгийн, өмнөх оны 272.7 сая төгрөгийн албан шаардлага бүрэн хэрэгжүүлж, 223.9 сая төгрөгийн албан шаардлагын хугацаа болоогүй үлдэгдэлтэй байна. (Дүрслэл 7)

Зөвлөмж: Тайлант хугацаанд 233 зөвлөмж өгснөөс 210, өмнөх оны үлдэгдэл 42 зөвлөмж хэрэгжиж, хугацаа болоогүй 23 зөвлөмж байна. (Дүрслэл 8)


Дүрслэл 6. Төлбөрийн акт (сая төгрөг)



Дүрслэл 7. Албан шаардлага (сая төгрөг)



Дүрслэл 8. Зөвлөмж (Тоо)



2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ


Төсөв захирагчид нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд болон СТОУС, НББОУС-д нийцүүлэн үнэн зөв тайлагнасан эсэхэд АДБОУС, МУЕА-ын баталсан ТАБ-ын санхүүгийн тайлангийн аудитын журам, ерөнхий чиглэлийн хүрээнд Төсвийн хуульд заасан цаглаварт хугацаанд санхүүгийн тайлангийн аудит хийж 55.6 сая төгрөгийн өртөг, 452 хүн өдөр зарцууллаа.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хамрагдсан байгууллага 222



Аудитын санал дүгнэлт 164



Аудитын илрүүлэлт – 23,478.4

Залруулсан -5,745.2

Залруулагдаагүй – 17,733.2



- Төлбөрийн акт - 125.2 мянган төгрөг
- Албан шаардлага - 12,939.6 сая төгрөг
- Зөвлөмж - 4,610.7 сая төгрөг
- Хариуцлага тооцуулах санал - 57.7 сая төгрөг



4,610.7 сая/төг
Зөвлөмж



57,7 сая/төг
Хариуцлага

■ Эхний үлдэгдэл
 ■ Тайлант онд тогтоосон
 ■ Хэрэгжсэн
 ■ Үлдэгдэл



Санхүүгийн тайлангийн аудитын үр дүн

Тайлант онд хуулиар тогтоосон чиг үүргийнхээ дагуу улс, орон нутгийн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит этгээд, төсөл хөтөлбөрийн 222 санхүүгийн тайланд аудит хийхээс 164 байгууллагад бие даан дүгнэлт гаргаж, 10 байгууллагад итгэл үзүүлж, 46 тайланг түүвэрт хамруулж, 2 байгууллагад аудит хийгдээгүй.

Санхүүгийн тайлангийн аудитаар 164 байгууллагын санхүүгийн тайланд өгсөн санал дүгнэлтийн 157 буюу 95.7 хувьд зөрчилгүй, 5 буюу 3.0 хувьд хязгаарлалттай, 1 сөрөг санал дүгнэлт өгч, 1 тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 23,478.4 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 5,745.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг санхүүгийн тайланд залруулсан. Аудитаар залруулагдаагүй 125.2 сая төгрөгийн 69 зөрчилд төлбөрийн акт, 12,939.6 сая төгрөгийн 160 зөрчилд албан шаардлага өгсөн бол 4,610.7 сая төгрөгийн 178 зөрчилд зөвлөмж өгч, 57.7 сая төгрөгийн 8 зөрчилд хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн.

Тайлант онд нийт 178 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан.

Тайлант онд тогтоосон 125.2 сая төгрөгийн болон өмнөх оны үлдэгдэл 6.1 сая төгрөгийн төлбөрийн актаас 2020 оны 12 дугаар сарын 11-ний байдлаар 114.2 сая төгрөгийн актыг барагдуулж ажилласан.


Мөн тайлант онд өгсөн нийт 12,939.6 сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжилтийг 100 хувь бүрэн хангуулан ажилласан.

Завсрын аудит


Завсрын аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж, аудитыг 2020 оны 09 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлүүлэн, хөтөлбөрт заасан хугацаанд жигд, чанартай гүйцэтгэхэд анхаарч ажиллалаа.

СТАУС программ дахь гүйцэтгэл 2020.09.09






СТАУС программ дахь гүйцэтгэл 2020.09.20



СТАУС программ дахь гүйцэтгэл 2020.10.09



Аудитад төсвийн шууд захирагчийн 90 байгууллагыг хамруулахаар төлөвлөснөөс 2020 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар 149 байгууллагыг хамруулж, гүйцэтгэлийг СТАУС программаар хянаж баталгаажууллаа.

Ирэх онд санхүүгийн тайлангийн аудитад хамрагдах нийт болон бие даасан дүгнэлт өгөх байгууллагуудын тоонд үндэслэн аудиторуудын ажлын ачааллыг тооцож, энэ онд завсрын аудитад хамрагдах байгууллагын тоог төлөвлөсөн хэмжээнээс 59 байгууллагаар нэмэгдүүлэн гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын үр нөлөө

Санхүүгийн тайлангийн аудитыг орон нутаг дахь бүх шатны төсөв захирагчид, санхүүгийн ажилтнуудыг оролцуулан хийж, аудит хийх багийн бүрэлдэхүүн, аудитаар баримтлах бодлого, чиглэл, үүрэг хариуцлагыг танилцуулж нээдэг болсноор шалгадагч байгууллагуудын аудитын үйл ажиллагаанд оролцох хариуцлага, хандлага сайжирсан.

Аймгийн хэмжээнд төсөв захирагчдын төрлөөр аудитын дүн, цаашид анхаарах асуудлын талаар нэгдсэн танилцуулгыг жил бүр хийснээр төсвийн хөрөнгийн зарцуулалт, түүнд тавих хяналт сайжирч, материаллаг шинж чанартай алдаа зөрчил буурч байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,355.3 сая төгрөгийн үр өгөөжийг бүртгэн, шалгадагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажууллаа.



ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудит

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 144 төсвийн байгууллага, 17 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 1 тусгай сан, 14 төвлөрүүлэн захирагч, нийт 176 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 164 байгууллага аудитад хамрагдаж, 10 байгууллагад итгэл үзүүлэн, тайланд онд үйл ажиллагаа явуулаагүй шалтгаанаар 2 байгууллага аудитад хамрагдаагүй.



848.2 сая төгрөг
ОНТЕЗ нийт алдаа зөрчил


Аудитаар нийт 848.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 286.0 сая төгрөгийн алдааг залруулж, 402.5 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 159.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өглөө.

ТЕЗ-ийн 2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Төсвийн тухай хуулийн 8.9.4-т заасны дагуу Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгагдсан нийт орлого ба тусламжийн 64,590.4 сая төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн 62,903.6 сая төгрөгийн гүйцэтгэлийг баталгаажуулж дүгнэлт гаргалаа.

Аудитаар нийт 3,072.5 сая төгрөгийн зөрчил илрүүлэн 3 зөвлөмж өгч, МУ-ын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгуулах 2 саналыг ҮАГ-т уламжлан аудитын тайланг ТА-ын тушаалаар баталгаажуулж төлөвлөгөөт хугацаанд нь аймгийн Засаг дарга болон ҮАГ-ын Санхүүгийн аудитын газарт хүргүүлсэн.

Дорнод аймгийн ТЕЗ-ийн 2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргасан.



Эерэг үр нөлөө

Аймгийн 2019 оны төсвийн нийт орлого төлөвлөгөөнөөс 7.5 хувь буюу 1,808.9 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Тайлант онд улсын төсөвт 1,686.8 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.



Сөрөг үр нөлөө

Аймгийн төсвийн нийт орлого төлөвлөгөөнөөс давж биелсэн ч хандив тусламжийн орлого 1.115,2 сая төгрөгөөр тасарсан нь эх үүсвэр тодорхойгүй, гэрээ хэлцэл бүрэн хийгдээгүй хандивын эх үүсвэрийг төлөвлөсөнтэй холбоотой байна.

Аймгийн төсвийн суурь зардлыг Сангийн яамнаас тогтоосон хязгаараас хэтрүүлэн төлөвлөж, зарцуулсан нь Сангийн яам Төсвийн хязгаарыг хянахдаа сумдын нөөц хөрөнгө болон төсөвт байгууллагуудын орон тоог улсын хэмжээн дэх жишиг үзүүлэлтийг харгалзан бодитой тооцохгүй байгаатай холбоотой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний 3.9 хувь хэрэгжээгүй нь төсвийн орлогыг баталгаагүй эх үүсвэрээс төлөвлөснөөс шалтгаалсан байна.

3. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Төрийн аудитын газар нь шалгагдаж буй байгууллагыг чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өөрийн нөөцийг арвич хямгач, үр ашигтай, үр нөлөөтэй ашиглаж байгаа эсэхэд АДБОУС, Гүйцэтгэлийн аудитын журмын хүрээнд аудит хийж, 73.8 сая төгрөгийн өртөг, 555 хүн/өдөр зарцууллаа.




ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



5
Аудит
гүйцэтгэсэн



72
Байгууллагыг
хамруулсан



Эх сурвалж: Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны статистик мэдээ

Гүйцэтгэлийн аудитын үр дүн

МУЕА-ын баталсан аудитын төлөвлөгөөний хүрээнд 2020 онд 5 аудитыг хийхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 100 хувь гүйцэтгэж 72 байгууллагыг хамруулан хийлээ.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 9.8 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж 36.6 сая төгрөгийн алдаа зөрчилд 7 төлбөрийн акт, 7.7 тэрбум төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 2.1 тэрбум төгрөгийн зөрчилд 41 зөвлөмж өгч ажиллалаа.

Төрийн аудитын газраас гүйцэтгэлийн аудитаар тайлант онд өгсөн 41 зөвлөмж, өмнөх оны үлдэгдэл 36, нийт 77 зөвлөмжийн 62 нь хэрэгжиж, хугацаа болоогүй 15 зөвлөмжийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд тогтоосон 36.6 сая төгрөг, өмнөх оны үлдэгдэл 72.4 сая төгрөг буюу нийт 109.0 сая төгрөгийн актаас 2020 оны жилийн эцсээр 65.3 сая төгрөгийн актыг барагдуулан төсөвт төвлөрүүлж, 1.0 сая төгрөгийн төлбөрийн акт шүүхийн шийдвэрээр хүчингүй болж 42.7 сая төгрөгийн актын үлдэгдэлтэй байна. Үүнээс 22.8 сая төгрөгийн төлбөрийн актын хугацаа болоогүй байна. Хугацаа болсон төлбөрийн актаас 16.7 сая төгрөгийн төлбөрийн акт нь шүүхийн шатанд, ШШГГ болон Прокурорын байгууллагад шилжсэн байна.

Мөн тайлант онд өгсөн 6, өмнөх оны үлдэгдэл 2 буюу нийт 8 албан шаардлагаас 7 албан шаардлага биелж өмнөх оноос шилжиж ирсэн 1 албан шаардлага хэрэгжээгүй байна.

Гүйцэтгэлийн аудитын үр нөлөө

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар болон газрын бодлого, шийдвэрийн хүрээнд өөрийн төлөвлөгөөгөөр, төсвийн хөрөнгийн зарцуулалт, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулах асуудлыг нотлох баримтад түшиглэн тайлагнаж, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллалаа.

Улсын хэмжээнд жил бүр давтан хийгдэж байгаа улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийж буй аудитын үр дүнд алдаа зөрчлийн төрөл буурч, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тавих хяналт сайжирсан байна.

Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Дорнод их сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Политехник коллежийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулах, түүний хэрэгжилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний бодит гүйцэтгэлд анхаарч, үр дүнг дээшлүүлэх, төгсөгчдийн ажлын байраар хангагдсан талаарх судалгааг нийт төгсөгчдөөр үнэн зөв, дэлгэрэнгүй гаргаж тайлагнах, ажлын байрны хангалтад дотоод, гадаад орчны шинжилгээ хийх, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг сайжруулах, дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөж байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах гэсэн зөвлөмжүүдийг өгч ажилласан.

“Төрөөс бүх нийтийн боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн”-д хийсэн аудитаар анх удаа цахимаар санал асуулга авсан.

Аймгийн хэмжээнд нийт 950 багш, ажиллагсад /захирал, багш, сургалтын менежер, нийгмийн ажилтан/ байгаагаас аудитын явцад ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны талаар 645 багш, ажиллагсад буюу 68 хувийг хамруулсан.

Эцэг, эхчүүдээс цахимаар санал асуулга авахад нийт 4828 эцэг, эхчүүд хамрагдсан.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 1,021.3 сая төгрөгийн үр өгөөжийг бүртгэн, шалгагдагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажууллаа.

Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг



11.3 тэрбум төгрөг
18 төсөл, арга хэмжээ



79.3%
Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл



86.1%
Санхүүжилтийн гүйцэтгэл



9,662. сая төгрөг
Илрүүлсэн алдаа
ЗӨРЧИЛ



Албан шаардлага **7,591.7** сая төгрөг
Зөвлөмж **2,070.6** сая төгрөг

Дорнод аймагт Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар 6 ТЕЗ-ийн багцад батлагдсан, 11.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл арга хэмжээний эрх шилжин ирж, тайлант онд 6.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдохоор батлагдсан байна.

Уг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 79.3 хувь буюу 5,362.4 сая төгрөг, нийт санхүүжилт 81.4 хувь буюу 5,507.9 сая төгрөг байна.

Аудитаар нийт 9,662.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж 7,591.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 2,070.6 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгч ажилласан.



Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд төлөвлөлтийн хангалтгүй байдал нөлөөлж байна гэж дүгнэлээ.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хуулийн шаардлагад нийцүүлэн, тооцоо судалгаанд үндэслэж, хэрэгцээ шаардлагаар эрэмбэлэх ажил хангалтгүй байгаа нь хөрөнгө оруулалтын бодлого зорилтот үр дүндээ хүрэхгүй байх үр дагаврыг үүсгэж байна гэж үзсэн.

Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн боловсролын болон их дээд сургуулиудын үйл ажиллагааны үр дүн

Аудитын дүн



124.7 сая төгрөг
Илрүүлсэн алдаа
ЗӨРЧИЛ



Төлбөрийн акт **31.7** сая төгрөг
Албан шаардлага **78.0** сая төгрөг
Зөвлөмж **15.0** сая төгрөг

Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Дорнод их сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Политехник коллежийн үйл ажиллагааны үр дүнд зохион байгуулалт, боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилт, орлогын төвлөрүүлэлт, хөрөнгө, санхүүгийн зарцуулалт гэсэн чиглэлүүдээр аудит хийлээ.

Аудитад 17.4 сая төгрөгийн өртөг, 176 хүн/өдөр зарцуулан, судалгаа, шинжилгээ хийх, ярилцлага, санал асуулга авах, тодруулга, тулган баталгаажуулалт хийх зэрэг горимуудыг хэрэгжүүлсэн.

Аудитаар нийт 124.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 31.7 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт, 78.0 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 15.0 сая төгрөгийн зөрчилд 18 зөвлөмж өгч ажиллалаа.

Сургуулиудын удирдлага зохион байгуулалт, хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлтийг гаргасан.

“Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах”

Аудитын дүн



734.4 мянган төгрөг
Илрүүлсэн алдаа
ЗӨРЧИЛ



Зөвлөмж **734.4** мянган төгрөг

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 04 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл”-д аудит хийлээ.

Нэгдсэн удирдамжийн хүрээнд аудитын дэд төлөвлөгөө, хөтөлбөрийг батлан, нээлтийг аймгийн Сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогчийг оролцуулан хийж, төлөвлөсөн цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэхэд анхааран, мэргэжил, арга зүйгээр хангаж, заавар зөвлөмжийг тухай бүрд өгч ажилласан.

Аудитыг ҮАГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу хугацаанаас өмнө гүйцэтгэж аудитаар 6 дүгнэлт, 734.4 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгч, тайланг ТА-ын тушаалаар баталгаажуулан аймгийн Сонгуулийн хороо болон ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газарт хүргүүлсэн.

“Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”





Санхүүжилтийн
гүйцэтгэл

393.5 сая төгрөг

Дорнод аймагт Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах аймгийн Сонгуулийн хорооны үйл ажиллагааны зардлын санхүүжилтэд Сонгуулийн ерөнхий хорооноос 393.5 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороодод зардлыг санхүүжүүлэхдээ тухай бүр аргачлал, зөвлөмжийг хүргүүлж хяналт тавьж ажилласан байна.

Дорнод аймагт Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийсэн аудитаар арвилан хэмнэлтгүй зардал гаргасан зөрчилд өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Аудитаар 5 дүгнэлт өгч ажилласан.

“Төрөөс бүх нийтийн боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн”

Аудитын дүн



10.4 сая төгрөг
Илрүүлсэн алдаа
ЗӨРЧИЛ



Төлбөрийн акт 4.9 сая төгрөг
Зөвлөмж 5.5 сая төгрөг

Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургуулиудын үйл ажиллагааны үр дүнд зохион байгуулалт, боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилт, хөрөнгө, санхүүгийн зарцуулалт гэсэн чиглэлүүдээр аудит хийлээ.

Аудитад 21.7 сая төгрөгийн өртөг, 220 хүн/өдөр зарцуулан, судалгаа, шинжилгээ хийх, ярилцлага, санал асуулга авах, тодруулга, тулган баталгаажуулалт хийх зэрэг горимуудыг хэрэгжүүлсэн.


Аудитаар мөнгөн дүнгээр нийт 10.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 4.9 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, ЕБС-ийн үйл ажиллагаа, хүний нөөц, гадаад болон дотоод орчин, хяналт, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалттай холбоотой 5.5 сая төгрөгийн зөрчилд 11 зөвлөмж, нэгтгэсэн тайланд тусгуулах 4 саналыг ҮАГ-т хүргүүлж ажиллалаа.

Бүх нийтийн ерөнхий боловсролыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу эзэмшүүлж байгаа суурь боловсролын чанар хангалтгүй байна гэж дүгнэсэ



4. НИЙЦЛИЙН АУДИТ

Төрийн аудитын газар нь шалгагдагч байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэлд нийцлийн аудит хийж, 88.3 сая төгрөгийн өртөг 550 хүн/өдөр зарцууллаа.



Нийцлийн аудитын үр дүн

МУЕА-ын баталсан аудитын төлөвлөгөөний хүрээнд 2020 онд 7 нийцэл, 1 эрсдэлийн аудитыг хийхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 6 нийцэл, 1

эрсдэлийн аудитыг 290 байгууллагыг хамруулан хийлээ. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүнг нийтэд мэдээлэх” нийцлийн аудитын хугацаа болоогүй байна. Нийцлийн аудитаар нийт 9.9 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж 2.9 тэрбум төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага, 5.6 тэрбум төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт, 1.3 тэрбум төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж өгч ажиллалаа.

Өмнөх оны үлдэгдэл 101.2 сая төгрөгийн төлбөрийн актаас 2020 онд 28.7 сая төгрөгийг барагдуулж 10.0 сая төгрөгийн төлбөрийн акт хүчингүй болж, 62.5 сая төгрөгийн төлбөрийн актын үлдэгдэлтэй байна.

Тайлант онд тогтоосон 5,632.0 сая төгрөгийн 5 төлбөрийн актаас 73.9 сая төгрөгийн 2 төлбөрийн акт барагдуулж, 5,558.1 сая төгрөгийн 3 төлбөрийн актын үлдэгдэлтэй байгаа нь барагдуулалтыг тооцох хугацаа болоогүй байна.

Өмнөх оны үлдэгдэл 122.9 сая төгрөгийн 6 албан шаардлага бүрэн хэрэгжсэн байна. Тайлант онд тавигдсан 2,957.6 сая төгрөгийн 13 албан шаардлагаас 2,733.7 сая төгрөгийн 8 албан шаардлага биелж, 223.9 сая төгрөгийн 5 албан шаардлагын үлдэгдэлтэй байгаа нь биелэлтийг тооцох хугацаа болоогүй байна.

Өмнөх оны үлдэгдэл 12.1 сая төгрөгийн 6 зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

Тайлант онд өгсөн 1,322.4 сая төгрөгийн 14 зөвлөмжөөс 45.3 сая төгрөгийн 6 зөвлөмж хэрэгжиж, 1,277.0 сая төгрөгийн 8 зөвлөмжийн үлдэгдэлтэй байгаа нь хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

Нийцлийн аудитын үр нөлөө

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын үр дүнд улс, орон нутгийн төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх зорилгод нийцүүлэн мэдээллийн агуулгыг сайжруулах чиглэлээр зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Төрд учирсан хохирлыг буцаан төлүүлэх чиг үүргийн хэрэгжилтэд аудит хийснээр тухайн асуудалд тавих хяналтыг сайжруулах, захиргааны шийдвэр гаргаж буй эрх бүхий албан тушаалтнуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх хөшүүрэг боллоо.

Орон нутгийн ээлжит сонгуульд оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн улс төрийн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, эдийн засгийн тооцоо судалгаанд дүгнэлт гаргах аудитын үр дүнд улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн.

Орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аудитын үр дүнд орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ тогтоогдож холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулагдаж, иргэд олон нийтэд мэдээлэгдсэн.

Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулах, дүгнэлт гаргах аудитын үр дүнд улс төрийн намуудын хандивын тайланг ТАБ-ын цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулж олон нийтэд мэдээлсэн.

Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн аудитын үр дүнд гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд нь хууль, тогтоомжид заасан хувь хэмжээний дотор гадаад ажилтан авч ажиллуулж, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангаж, ажилтай орлоготой байх боломжийг бий болгох талаарх ойлголт, хариуцлага нэмэгдсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын үр дүнд орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг журамд заасан бүс нутгийн хөгжлийг дэмжих зорилгод нийцүүлэн төсөл, арга хэмжээг төлөвлөх чиглэлээр зөвлөмж өгч ажилласан.

Нийцлийн аудитаар нийт 5,677.3 сая төгрөгийн үр өгөөжийг бүртгэсэн.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Аудитын дүн



Улсын төсвийн **43**
Орон нутгийн **171**
Нийт **214**



Зөвлөмж **3**
Санал **1**



Бүрэн мэдээлсэн **71.7%**
Хугацаа хоцролт **20%**

Шилэн дансны тухай хууль 2015 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхэлснээс хойш нэгдсэн удирдамжаар нийцлийн аудит хийж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь нэгдсэн цахим санд байршуулсан эсэхийг төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох баримт, нотлох зүйлстэй тулган шалгасан тайланг орон нутгийн ТЕЗ болон ҮАГ-т хүргүүлж, олон нийтэд мэдээлж ирсэн.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2020 онд хийсэн аудитаар улсын төсвийн 43, орон нутгийн төсвийн 171 нийт 214 байгууллагыг хамруулсан.


Аймгийн ТЕЗ-ийн төсөвт хамаарах байгууллагуудын хувьд мэдээллүүдийг бүрэн мэдээлэх байдал 71.7 хувь, хугацаа хоцролт 20.0 хувьтай байна.

Шилэн дансны цахим хуудсанд Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын батлан хамгаалах салбарын төрийн нууцад хамаарах мэдээллийг байршуулж байгаа, төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудыг хяналт шалгалтад бүрэн хамруулж, мэдээллийн агуулгыг бодитой үнэлж, дүгнэж байх шаардлагатай байгаа талаар тайланд тусгасан.

Аудитаар мэдээллийг бүрэн байршуулах талаар ТЕЗ-д 1 албан шаардлага, улсын төсвийн байгууллагуудын ТШЗ-дад 7 албан шаардлага, дотоод хяналтыг сайжруулах талаар ТЕЗ-д 3 зөвлөмж өгч нэгтгэсэн тайланд тусгуулах 1 саналыг ҮАГ-т хүргүүлсэн.

Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт

Аудитын дүн





57.1 сая төгрөг
Илрүүлсэн алдаа
ЗӨРЧИЛ



Албан шаардлага 11.8 сая төгрөг
Зөвлөмж 45.3 сая төгрөг

Захиргааны ерөнхий хууль 2016 оны 07-р сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн бөгөөд уг хуулийн 103.1, 103.2, 103.3 дахь заалтуудаар иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх харилцааг зохицуулсан.

Дээрх зохицуулалтаар захиргааны байгууллагад учирсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар төлүүлэх үүргийг дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгжид, дотоод аудитын нэгж байхгүй бол Төрийн аудитын байгууллагад хариуцуулсан.

Энэ чиглэлээр 2016 оноос хойш тусгайлан аудит хийгдээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн аудитын явцад иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсан ч төрд учирсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлээгүй байх эрсдэл өндөр байсан тул 2020 онд өөрийн төлөвлөгөөгөөр аудит хийхээр МУЕА-ын баталсан аудитын төлөвлөгөөнд тусгуулсан.

Дорнод аймгийн хэмжээнд 2017-2019 онд захиргааны байгууллагын албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас иргэнд учирсан 84.5 сая төгрөгийн хохирлыг төрөөс олгуулах шүүхийн шийдвэр гарсан байна.

Дорнод аймгийн төрийн албаны салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хуулийн 50.2, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам-ын 1.2, 3.4.3, 3.6.4 дэх заалтуудын дагуу төрд учирсан хохирлыг тооцох, нөхөн төлүүлэх талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулж ажиллаагүй, дотоод аудитын нэгж болох Санхүүгийн хяналт, аудитын алба нь төрд учирсан хохирлыг буцаан төлүүлэх үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна гэсэн дүгнэлтийг гаргасан.

Аудитаар нийт 57.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс улсын төсөвт байгууллагуудын ТЕЗ-дийн дотоод аудитын нэгжид хамаарах 11.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэх саналыг YAГ-т хүргүүлж, орон нутгийн ТЕЗ-д хамаарах байгууллагуудын 45.3 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч ажиллалаа.

Орон нутгийн ээлжит сонгуульд оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн улс төрийн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, эдийн засгийн тооцоо судалгаанд дүгнэлт гаргах

Аудитын дүн



Намын мөрийн хөтөлбөр
Дүгнэлт **49**



Бие даан нэр дэвшигч
Дүгнэлт **79**

МУЕА-ын баталсан аргачлалын дагуу, YAГ-аас зохион байгуулсан арга зүйн цахим сургалтад хамрагдаж, төлөвлөлтийн өмнөх үе шатны ажлуудыг гүйцэтгэн, сонгуульд оролцох намуудад ажлын захидлаар мөрийн хөтөлбөрийг бэлтгэн ирүүлэх загвар, маягтуудын хамт хүргүүлсэн.



Аудитыг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэж 7 намын 49, бие даан нэр дэвшигчийн 79 мөрийн хөтөлбөрт дүгнэлт гарган хуульд заасан хугацаанд Сонгуулийн хороо болон нам, нэр дэвшигчдэд хүргүүлсэн.

Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуульд заасны дагуу мөрийн хөтөлбөрт өгсөн дүгнэлтүүдийг хуулийн хугацаанд ТАБ-ын цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулж олон нийтэд мэдээлсэн.

Орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох

Аудитын дүн



Аймгийн ИТХ
Намын 1
Нэр дэвшигчийн 24



Сумын ИТХ
Намын 14
Нэр дэвшигчийн 67

Орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтооход төсвийн 3, орон нутгийн төсвийн 5 нийт 8 байгууллагыг хамруулсан.

Арга зүйн талаар ҮАГ-аас зохион байгуулсан цахим сургалтад хамрагдаж, шаардлагатай тохиолдолд НАГ-аас тухай бүр заавар, зөвлөмж авч ажилласан.

Аймгийн ИТХ-ын сонгуульд оролцох намын зардлын 1, нэр дэвшигчдийн зардлын 24 дээд хэмжээ, сумдын ИТХ-ын сонгуульд оролцох намын зардлын 14, нэр дэвшигчдийн зардлын 67 дээд хэмжээ тогтоох ажлыг гүйцэтгэж хуульд заасан хугацаанд нь нийтэд мэдээлсэн.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүнг нийтэд мэдээлэх

Аудитыг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2.5 дахь заалт, Тэргүүлэх аудиторын 2020 оны 23 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэл”-д хийх аудитын гүйцэтгэлийн үе шатны ажилбар 80.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд төлөвлөгөөний дагуу үргэлжилж байна.

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

- Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн санхүүжилтээ хуулийн дагуу бүрдүүлсэн эсэх.
- Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛИЙН ОРЛОЦОЖ БАЙГАА НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН
СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭЛТ
АУДИТ ХИЙЖ, ДҮНГ НИЙТЭД МЭДЭЭЛЭХ



АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дөрөмд ойнны дахь Төрийн нурууны газар
2020 он

эсэх.

- Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэг нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг баримталсан эсэх.

Аймаг нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцсон 5 нам, 233 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг ирүүлээд байна.

Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулах, дүгнэлт гаргах

Аудитын дүн



7 намын хандивын тайлан



49 дүгнэлт

МУЕА-ын баталсан зааврын дагуу, ҮАГ-аас зохион байгуулсан арга зүйн цахим сургалтад хамрагдаж, төлөвлөлтийн өмнөх үе шатны ажлуудыг гүйцэтгэн, сонгуульд оролцох намуудад хандивын тайлан бэлтгэн ирүүлэх загвар, маягтуудыг, 2019 оны санхүүгийн тайлангийн хамт ирүүлэх албан бичгийг хүргүүлсэн.

Аудитыг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэж 7 намын 49 хандивын тайланд дүгнэлт гарган хуульд заасан хугацаанд Сонгуулийн хороо болон намуудад хүргүүлсэн.

Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуульд заасны дагуу хандивын тайланд өгсөн дүгнэлтүүдийг хуулийн хугацаанд ТАБ-ын цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулж олон нийтэд мэдээлсэн.

Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт

Аудитын дүн



5,626.0 сая төгрөг
Илрүүлсэн алдаа
ЗӨРЧИЛ



Төлбөрийн акт 5,626.0 сая төгрөг
Зөвлөмж 4
Санал 1

Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг аймгийн ИТХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.


Аудитад 12.0 сая төгрөгийн өртөг, 176 хүн/өдөр зарцуулан, холбогдох байгууллагуудаас цуглуулсан баримт материалд дүн шинжилгээ хийх, газар дээр нь очиж үзэх, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тодруулга, тайлбар авах зэрэг горимуудыг хэрэгжүүлсэн.





Аудитаар 5,626.0 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, холбогдох албан тушаалтнуудад 4 зөвлөмж өгч, УАГ-т аудитаар илэрсэн асуудлыг шийдвэрлүүлэх талаар 1 саналыг хүргүүлсэн.

Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд хууль, тогтоомжид заасан хувь хэмжээнээс илүү авч ажиллуулсан гадаад ажилчдын ажлын байрны төлбөрийг төсөвт төлөөгүй байна гэсэн дүгнэлтийг гаргасан.


Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт

 **10.3** тэрбум төгрөг
307 төсөл, арга хэмжээ

 **85.6%**
Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл

 **84.8%**
Санхүүжилтийн гүйцэтгэл

 **1,507.0** сая төгрөг
Илрүүлсэн алдаа **ЗӨРЧИЛ**

 Төлбөрийн акт **6.0** сая төгрөг
Албан шаардлага **223.9** сая төгрөг
Зөвлөмж **1,277.1** сая төгрөг

Аймгийн ИТХ-аар орон нутгийн хөгжлийн сангийн төсвийг ОНХНС-гаас 6,104.7 сая төгрөг, гадаад дотоодын хандив тусламжаас 4,253.5 сая төгрөг нийт 10,358.2 сая төгрөгийн санхүүжилтээр бүрдүүлэхээр баталсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулахад ОНХНС-гаас санхүүжих орлого 96.3 хувь, дотоод гадаадын хандив тусламжаас орох орлого 73.3% хувь нийт орлогын гүйцэтгэл 84.8 хувьтай байна. ОНХС-гийн хөрөнгөөр 2019 онд нийт 307 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 263 төсөл, арга хэмжээг санхүүжүүлж төсөл арга хэмжээний гүйцэтгэл 85.6 хувьтай байна.

Аудитаар нийт 1,507.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн 6.0 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоон, зөрчил арилгуулах 223.9 сая төгрөгийн 5 албан шаардлага, 1,277.1 сая төгрөгийн 4 зөвлөмж өгч ажилласан.



ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох хууль, журамд заасан ажлуудыг бүрэн хийхгүй байгаа нь гүйцэтгэлд нөлөөлж байна гэж дүгнэсэн.

Цаашид орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг журамд заасан бүс нутгийн хөгжлийг дэмжих зорилгод нийцүүлэх шаардлагатай гэж үзсэн.

5. ИТХ-ЫН ХҮСЭЛТЭЭР БОЛОН ӨӨРИЙН САНААЧИЛГААР ХИЙСЭН АУДИТ

ТАБ-ын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөнд ИТХ-ын хүсэлтээр “Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилт”-д нийцлийн аудит, Өөрийн төлөвлөгөөгөөр “Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт”-д эрсдэлийн аудит, “Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн боловсролын болон их дээд сургуулиудын үйл ажиллагааны үр дүн”, “Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д гүйцэтгэлийн аудит хийх саналыг ҮАГ-т хүргүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын “Аудитын төлөвлөгөө батлах тухай” тушаалаар батлуулсан.

Гүйцэтгэл, нийцлийн болон эрсдэлийн аудитыг төлөвлөгөөт хугацаанд бүрэн гүйцэтгэж тайланг ТА-ын тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.


ТАБ-ын статистик мэдээ гаргах журам, маягад эрсдэлийн аудит гэсэн төрөл тусгагдаагүй тул ҮАГ-ын СУГ-аас чиглэл авч нийцлийн аудитын дүнд оруулан тайлагнасан.

Аудитуудын талаарх мэдээллийг статистик мэдээний дүнтэй уялдуулан гүйцэтгэл, нийцлийн аудитын бүлэгт дэлгэрэнгүй тусгасан.

6. ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ

Өмнөх жилүүдэд төсвийн төсөл хэлэлцэх Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанд төсвийн орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах, үр ашиг сайжруулах төсөл хөтөлбөрийн жагсаалтыг мөнгөн дүнгийн хамт танилцуулдаг байсныг аудитын тайлангийн агуулга бүхий цогц дүгнэлт болгон танилцууллаа.


Аймгийн 2021 оны төсвийн төсөлд төсвийн үр ашгийг сайжруулах 7.5 тэрбум төгрөг, төсвийн орлогыг нэмэгдүүлэх 37.4 сая төгрөг, төсвийн зарлагыг бууруулах 2.7 тэрбум төгрөгийн санал, дүгнэлтийг хүргүүлсэнд хариуг албан бичгээр ирүүлсэн.





7. ДОТООД АЖИЛ

Сургалт



Дотоод сургалт

ТАБ-ын Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан “Нийгмийн бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээний асуудалд үнэлэлт дүгнэлт өгөх мэдлэг, чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх” зорилтын хүрээнд МУЕА-ын 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/76-1 тушаалаар батлагдсан ТАБ-ын 2020 оны сургалтын төлөвлөгөө болон ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилгоор тусгасан арга хэмжээг харьцуулан судалж газрын 2020 оны дотоод сургалтын чиглэл, арга зүйг тодорхойллоо.

Сургалтын төлөвлөгөөг боловсруулахдаа албан хаагчдын сайжруулах ур чадварыг аудитын менежерээс санал авах мөн ажилтнуудаас сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох чиглэлээр санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгийн үр дүнг харгалзан нийт 6 төрлийн сургалт зохион байгуулахаар баталж хэрэгжүүлсэн.

Мөн ҮАГ-аас зохион байгуулсан сургалтаар өгсөн мэдлэгийг түгээх сургалтуудыг зохион байгуулж хэвшсэн бөгөөд Тэргүүлэх аудитор орон нутгийн сонгуулийн хууль хэрэгжүүлэхтэй холбоотой хийгдэх аудитын үйл ажиллагаанд ашиглах арга зүйн талаарх мэдлэгийг түгээх 3 удаагийн сургалт зохион байгуулж, аудитын дээд байгууллагын олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж, батлуулсан Төрийн аудитын Монгол Улсын стандартын агуулгыг ойлгох, судлах ажлыг зохион байгуулж арга зүй өгч ажилласан.

Албаны нууцад хамаарах мэдээлэл нь энгийн харилцаанаас эхлэн санаандгүй байдлаар хэрхэн алдагдаж болох тухай нийт албан хаагчдад кейс бэлтгэн танилцуулж, гарах үр дагавар, цаашид анхаарах асуудлын талаар чиглэл өгөх сургалтыг зохион байгуулж нийт ажилтнуудыг бүрэн хамруулсан.

Microsoft Word, Excel, Adobe Photoshop программын ашиглалтыг сайжруулах зорилтын хүрээнд төрөл бүрийн диаграм, график, хүснэгтийг тайланд ашиглах, зураг, дүрслэлийг хүссэн хэмжээгээр өөрчлөх, өнгө, дүрслэлийг сайжруулах

талаарх сургалтыг нийт албан хаагчдын дунд 2020 оны 06 дугаар сард зохион байгуулсан.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хөдөлгөөн засалч, Биеийн тамир спортын газрын нийтийн биеийн тамирын арга зүйч нарыг урьж дараах чиглэлүүдээр сургалт авсан. Үүнд:

- өдөр тутмын зохистой хөдөлгөөнийг хэрхэн хийх
- тулгуур эрхтэнтэй холбоотой зарим төрлийн өвчнийг дасгал хөдөлгөөнөөр эмнэх
- нийтийн биеийн тамираар хичээллэх

Сургалтын үр дүнг сайжруулж, өдөр тутамд дасгал хөдөлгөөн хийх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор хамтын сангаар нурууны сунгалтын дасгал хийх төхөөрөмж худалдан авч ажлын байранд тогтмол ашиглаж байна.

Цахим сургалтыг аудитор Я.Зоригт хариуцуулж ажиллуулж байна.

ҮАГ-аас хийсэн сургалт

ТАБ-ын хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулагдсан сургалтуудад тухай бүр оролцон, өгсөн чиглэл арга зүйг хэрэгжүүлэн ажиллалаа.

- Нэгдсэн удирдамжаар хийгдэж байгаа “Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийх аудитыг гүйцэтгэх арга зүйн талаарх онлайн сургалтад гүйцэтгэлийн аудитын албаны аудиторууд болон чанарын хяналт хэрэгжүүлэх албан тушаалтнууд хамрагдсан.
- Нэгдсэн удирдамжаар хийгдэж байгаа “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийгдэж байгаа аудитыг гүйцэтгэх арга зүйн талаарх онлайн сургалтад нийцлийн аудитын албаны аудиторууд болон чанарын хяналт хэрэгжүүлэх албан тушаалтнууд хамрагдсан.
- Нэгдсэн удирдамжаар хийгдэж байгаа “Төрөөс бүх нийтийн боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн” -д хийх аудитыг гүйцэтгэх арга зүйн талаарх онлайн сургалтад гүйцэтгэлийн аудитын албаны аудиторууд болон чанарын хяналт хэрэгжүүлэх албан тушаалтнууд хамрагдсан.
- Нэгдсэн удирдамжаар хийгдэж байгаа “Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт” -д хийх аудитыг гүйцэтгэх арга зүйн талаарх онлайн сургалтад нийцлийн аудитын албаны аудиторууд болон чанарын хяналт хэрэгжүүлэх албан тушаалтнууд хамрагдсан.
- Орон нутаг дахь ТАГ-ын удирдлагуудын цахим хуралд Тэргүүлэх аудитор, аудитын менежер нар хамрагдсан. Хурлаар МУЕА-ын орлогч С.Бүрэнбат, ҮАГ-ын ТГ-ын дарга Ц.Ганболд, Хууль, эрх зүйн менежер Н.Анхбаяр нар нууцын хадгалалт, хамгаалалт, авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах талаарх арга зүй болон цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой чиглэлүүд өгсөн.
- Аймаг, сумдын ИТХ-ын сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой хийгдэх аудитнуудын талаар НАГ-аас зохион байгуулсан арга зүйн цахим сургалтуудад аудиторууд болон, аудитыг хянан удирдах ажилтнууд хамрагдсан.
- ҮАГ-аас зохион байгуулсан “Орон нутгийн сонгуулийн хууль хэрэгжүүлэхтэй холбоотой хийгдэх аудитын үйл ажиллагаанд арга зүй өгөх семинар”-т дарга бөгөөд Тэргүүлэх аудитор оролцсон.
- Ёс зүйн дүрэм, ёс зүйн өмгөөллийн сургалтад ажилтнууд хамрагдсан.

- ҮАГ-аас цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл болон аудитын үйл ажиллагаатай холбоотой арга зүйн сургалтуудыг цаг тухай бүрд нь өгч ажиллаж байгаа нь орон нутаг дахь байгууллагуудын бодлого, шийдвэр, тулгамдсан асуудлыг нэг арга зүйгээр ижил түвшинд шийдвэрлэх байдлыг нэмэгдүүлсэн үр дүнтэй ажил болж байна.
- Төрийн аудитын “surgalt.audit.mn” цахим сургалтын системээр Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар бэлтгэгдсэн хуулийн хэрэглээ хичээлийг судалж бүх ажилтнууд явцын болон эцсийн тест сорилыг өгч албан хаагчдын нийт дундаж үзүүлэлт 90 хувьтай үнэлэгдлээ.

Бусад сургалт

Ажилтнуудын мэдлэгийн хүрээ, мэргэшил, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор мэргэжлийн сургалтын байгууллагад болон бие даан суралцах сургалтыг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулан баталсан.

ҮАГ-аас Удирдлагын академитай хамтран зохион байгуулж байгаа ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалтнуудын мэргэшүүлэх багц сургалтад 3 ахлах аудитор хамрагдаж, бие даан судлах 8 сэдвийг судлан, мэдлэгийг баталгаажуулах шалгалт өгч тэнцэн сертификатаа авсан.

Мөн Тэргүүлэх аудитор Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх улирлын багц сургалтад хамрагдан 8 хичээл судалж, шалгалт өгөн дүнгээ гаргуулаад байна.

ММНБИ-ээс зохион байгуулсан мэргэшсэн нягтлан бодогчийн эрх сунгах, аудиторын эрх олгох цахим сургалтуудад 3 аудитор хамрагдаж аудиторын эрх авч, 1 аудитор МНБ-ийн эрхээ сунгасан.

Монгол УИХ, Төрийн албаны зөвлөл, НҮБ, Канад Улсын ЗГ-аас хамтран зохион байгуулсан “Чадахуйн зарчмын хэрэгжилт ба хүний нөөцийн аудит” сэдэвт сургалтад Тэргүүлэх аудитор хамрагдсан.

Монгол Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Төрийн албаны ёс зүйн зөвлөлийн нэгдсэн зөвлөгөөн”-д бүх ажилтнууд zoom программ ашиглан цахимаар оролцсон.

Архивын ерөнхий газраас зохион байгуулсан “Архивын хууль, тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх” талаарх цахим сургалтад Тэргүүлэх аудитор хамрагдсан.

Сангийн яам болон аймгийн ЗДТГ-ын хамтран зохион байгуулсан УСНББОУС-ын мэдлэг олгох 2 өдрийн сургалтад нягтлан бодогч болон санхүүгийн аудитын албаны ажилтнууд хамрагдаж сертификат авсан.

MERIT төслөөс бэлтгэсэн “Ахисан түвшний жендерийн дүн шинжилгээ” сургалтад Тэргүүлэх аудитор цахимаар хамрагдан судалж, шалгалт өгсөн.

Хамтын ажиллагаа



Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан “Харилцагч талуудын үр ашигтай хамтын ажиллагааг дэмжиж, аудитын чанар, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг дээшлүүлэх” зорилтын хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлж, бодит үр дүн нэмэгдүүлэхээр дараах ажлуудыг зохион байгууллаа.

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудитын урьдчилсан судалгааны ажлыг гүйцэтгэхтэй холбогдуулан худалдан авах ажиллагааны шалгаруулалтад оролцсон орон нутаг дахь барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдтэй хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүн, хүндрэл бэрхшээлийн талаарх уулзалтыг зохион байгуулж, хамтран ажиллалаа.

Мэдээлэл сурталчилгаа



ТАБ-ын “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, төрийн аудитын байгууллагын идэвх оролцоог нэмэгдүүлэх замаар сайн засаглалыг дэмжих” стратегийн зорилтын хүрээнд төрийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд ил тод мэдээлэх, байгууллагын үйл ажиллагааны талаар иргэдийг бодит мэдээллээр хангах чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулж ажиллалаа.

- Орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ТАБ-ын талаар олон нийтэд түгээж, мэдээлэх зорилгын хүрээнд “Дорнод ТВ”-тэй 2020 онд хамтран ажиллах гэрээ байгуулсан.
- Санхүүгийн тайлангийн аудитын нээлтийг төсвийн захирагчид, санхүүгийн ажилтнууд, гэрээт аудитын компанийн төлөөллийг, оролцуулан хийж, орон нутгийн ТВ-ээр мэдээлж ажиллалаа.
- “Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийх гүйцэтгэлийн аудитын нээлтийг аймгийн Засаг дарга болон холбогдох газар, хэлтсийн удирдлага, мэргэжилтнүүдийг оролцуулан хийж, орон нутгийн ТВ-ээр мэдээлж ажиллалаа.
- “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийх нийцлийн аудитын нээлтийг аймгийн Засаг дарга болон холбогдох алба, хэлтсийн удирдлага, мэргэжилтнүүдийг оролцуулан хийж, орон нутгийн ТВ-ээр мэдээлж ажиллалаа.
- ТШЗ, ТБОНӨААН, ТТЗ-дын байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, цаашид анхаарах асуудлуудын талаарх мэдээллийг төсөв захирагчдын төрөл тус бүрээр аймгийн удирдлагуудын шуурхай хуралдаан болон орон нутгийн ТВ-ээр мэдээлж ажиллалаа.
- Гүйцэтгэл болон нийцлийн аудитаар сумдад ажиллахдаа газрын 2020 онд гүйцэтгэх төлөвлөгөөт аудитууд болон ТШЗ-ийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаарх мэдээллийг түгээх ажлыг хамтатган зохион байгуулж ажиллалаа.
- Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар эх бэлтгэж төсөвт байгууллагын нийт санхүүгийн ажилтнуудад хуулийн шинэчлэлийг танилцуулж Төрийн аудитын байгууллагыг сурталчилж ажилласан.

- Фэйсбүүк хуудсанд 4 дүгээр улирлын байдлаар газрын үйл ажиллагааны талаар нийт 32 мэдээлэл байршуулсан нь 21654 хандалт авсан байна.
- Төрийн аудитын байгууллагын нэгдсэн audit.mn цахим сайтад гүйцэтгэл, нийцлийн 9 аудитын тайлан, 3 аудитын төлөвлөгөө, аудитын үйл ажиллагааны талаар 24 мэдээлэл тус тус байршуулсан.
- Авлигын эсрэг хуулийн 5.1.2, 6.1.6 дахь заалтад заасан үүргийн хүрээнд АТГ-аас гаргасан богино хэмжээний шторкуудыг байгууллагын FB хуудасны нүүр мэдээлэл болгон байршуулж нийтэд түгээсэн.

Албан харилцаа



Газрын хэмжээнд төлөвлөгдсөн албан бичгүүд, акт, албан шаардлагын утга найруулга болон хууль зүйн үндэслэл болон тушаалын төслүүдийн боловсруулалтад хяналт тавьж, аудит болон үйл ажиллагаанд тулгамдсан асуудлуудын талаар МУЕА-ын орон нутаг хариуцсан орлогч, ҮАГ-ын төрөлжсөн аудитын газрууд болон Тамгын газраас заавар, зөвлөмж авч ажиллалаа.

Газрын 2020 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гарган баталж, албан бичгийн бүртгэлийн цахим санг үүсгэн, албан бичгүүдийн шийдвэрлэлтэд бүртгэлээр хяналт тавьж хариуг хугацаанд нь өгч ажилласан.

2020 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар цаасаар 1449 удаагийн 9388 хуудас, цахимаар 223 удаагийн 344 хуудас албан бичиг эргэлтэд орсноос явсан бичиг 761, ирсэн бичиг 722, тушаал 30, төлбөрийн акт 84, албан шаардлага 181, хурлын тэмдэглэл 35, бусад /аудитын тайлан, гэрээ, мэдээлэл зэрэг бусад 351 удаа хэвлэлтэд орж, 9475 хуудас гарсан байна.

Баримт материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд АЗДТГ-т хүсэлт тавьж архивын өрөөтэй болох асуудлыг шийдвэрлүүлж, өөрийн төсвөөр засварын ажлыг хийн тохижуулж 960.0 мянган төгрөгийн баримтын шүүгээ 2-ийг нэмж хадгаламжийн нэгжүүдийг шилжүүлэх ажлыг зохион байгууллаа.

Хүний нөөцтэй холбоотой судалгаа, мэдээ тайланг ҮАГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу цаг тухай бүрд гарган хүргүүлсэн. Үүнд:

- Хүний нөөцийн хөдөлгөөн өөрчлөлтийн мэдээг гарган сар бүр ҮАГ-ын хүний нөөцийн мэргэжилтэнд хүргүүлсэн.
- Ажилтнуудын албан тушаал, шагнал зэрэг болон бусад мэдээллийн талаарх судалгааг ирүүлсэн чиглэлийн дагуу тухай бүр гарган ҮАГ-ын холбогдох албан тушаалтнуудад цаг хугацаанд нь хүргүүлж ажилласан.
- Засгийн газрын 163 дугаар тогтоолын дагуу Төрийн албаны цалингийн нэгдсэн системд нэвтрэх ажлыг гүйцэтгэн, холбогдох мэдээлэл өөрчлөлтийг бүрэн хийж, 2020 оны 9 дүгээр сараас эхлэн уг системээр цалингаа олгож байна.
- Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр дүгнэж, Газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын 2020 оны 1, 2, 3-р улирлын

гүйцэтгэлийн тайлан, газрын 2020 оны эхний хагас болон жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гарган ҮАГ-т хүргүүлсэн.

- Газрын 2020 оны эхний хагас жилийн болон жилийн эцсийн статистик мэдээ, үйл ажиллагааны тайланг 12-р сарын 15-ны өдрөөр тасалбар болгон МУЕА-ын баталсан журмын дагуу үзүүлэлт бүрээр дэлгэрэнгүй гарган ҮАГ-ын Стратеги удирдлагын газарт цаг хугацаанд нь хүргүүлж ажиллалаа.
- Газраас 2020 онд үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн шинэлэг ажлуудыг гаргаж Тамгын газарт 2020 оны 12 дугаар сарын 10-нд цахимаар хүргүүлсэн.

Өргөдөл гомдол



Газрын хэмжээнд өргөдөл, санал, гомдол ирээгүй бөгөөд Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1, 6-р хавсралтад заасан заалтууд өндөр насны тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа эмч нарт олгогдох эсэх талаар зөвлөн туслах хүсэлт ирүүлсний дагуу зөвлөмжийг албан бичгээр хүргүүллээ.

Галлагаатай байшинд амьдардаг 2 албан хаагч түлээ нүүрсний хөнгөлөлт авах хүсэлт гаргасныг зохих зардлаас гаргаж, шийдвэрлэж өгсөн.

Аудитын менежер В.Цэнгэлмаа өөрийн хүсэлтээр өөр байгууллагад шилжин ажиллах өргөдөл гаргасныг ҮАГ-т уламжилж шийдвэрлүүлсэн.

Төрийн аудитын байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 5.8-д заасны дагуу эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар хүсэлт гаргасан 8 ажилтанд 14 өдрийн цалинтай чөлөө олгож ажиллалаа.

Шагнал урамшуулал



ҮАГ-аас Covid19–н нөхцөл байдалтай холбогдуулан ирүүлсэн чиглэл, тушаалыг үндэслэн халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын үед хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган 0-12 насны хүүхэдтэй болон эрүүл мэндийн шалтгаантай ажилтнуудад цалинтай чөлөө олгох, ажлын цагийг богиносгох асуудлуудыг шийдвэрлэн, ажлын өрөө, тасалгаануудад ариутгал хийх, ажилтнуудыг амны хаалтаар хангах, дархлааг дэмжин, витаминжуулах ажлуудыг зохион байгуулж ажиллалаа.

МУЕА-ын баталсан дотоод журамд заасны дагуу уламжлалт Цагаан сар болон ахмадын баярын хүрээнд байгууллагын ахмадуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн, гарын бэлэг гардуулсан.

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр албан хаагчдынхаа хүүхдүүдэд гарын бэлэг өгсөн нь албан хаагчдын ажилдаа хандах хандлагад урам дэм боллоо.

ТАБ-ын 25 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд идэвх чармайлт, үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилтнуудыг төрийн дээд одон медаль болон бусад шагналаар шагнуулах хүсэлтийг холбогдох газруудад хүргүүлсний үндсэн дээр аудитын менежер В.Цэнгэлмаа “Төрийн хяналтын тэргүүний ажилтан” цол, тэмдэг, ахлах аудитор Б.Дэлгэрмаа Төрийн дээд шагнал “Алтан гадас” одон, “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдэг, аудитор С.Энхбаатар Төрийн аудитын байгууллагын “Хүндэт жуух бичиг”-ээр тус тус шагнагдсан.

Нууцын хадгалалт хамгаалалт



Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмыг мөрдлөг болгон дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- МУЕА-ын А/108 тушаалаар батлагдсан төрийн болон албаны нууцыг хамгаалах дотоод журмын дагуу нийт албан хаагчдаас нууцын баталгааг гаргуулан авсан.
- Төрийн нууцтай танилцах эрхийн лавлагааг Хилийн болон Зэвсэгт хүчний ангиудад аудит хийх ахлах аудиторуудад гарган ажилласан.
- Тагнуулын ерөнхий газрын Дорнод аймаг дахь газарт нууц хамгаалах, хадгалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын тайланг хүргүүллээ.
- Тагнуулын газраас аймгийн хэмжээнд төрийн болон албаны нууц хадгалах, хамгаалах чиглэлээр хийсэн шалгалтаар өгсөн зөвлөмжийн хариуг албан бичгээр хүргүүлэн ажиллалаа.
- Нууцын хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, өрөөтэй болгох асуудлыг шийдвэрлэн, өөрийн төсвөөр 885.0 мянган төгрөгийн 2 хяналтын камер, дэлгэц суурилуулж, нууцтай холбоотой баримтуудыг шилжүүлсэн.
- Төрийн болон албаны нууц хамгаалах хууль, тогтоомжийн хүрээнд Хилийн болон Зэвсэгт хүчний ангиудын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудиттай холбоотой баримтуудыг нууцын ажилтанд цаг тухай бүрд нь шилжүүлэн ажилласан.
- МУЕА-ын 2020 оны А/56 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын 2.3-т заасны дагуу сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой аудитад томилогдсон аудиторуудаас нууцын баталгаа болон ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл гаргуулсан.
- Мэдээлэл гадагш задруулсан нь тогтоогдвол хуулийн хариуцлага хүлээх тухай танилцуулж, гарын үсгээр баталгаажуулсан.
- Сонгуулийн мөрийн хөтөлбөр хүлээн авах, дүгнэлт гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор нууцын өрөөг уг аудитад ашиглахаар бэлтгэн, гар утас ашиглах боломжийг хязгаарлан, суурин утас байршуулсан.
- Сонгуулийн мөрийн хөтөлбөр болон хандивын баримтуудыг нууцаас гаргаж архивын нэгж болгож бичиг хэрэгт хүлээлгэн өгсөн.

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх



- ҮАГ-аас өгсөн чиглэлийн дагуу ажилтнуудад ТАБ-ын хөдөлмөрийн дотоод журам болон ёс зүйн дүрмийг сэргээн судлуулах, НАНБХАСЗАСЗУСТ, ГХЗУСТ, Авлигын эсрэг хуулиудыг судлуулах ажлуудыг зохион байгуулж ажилласан.
- Ажилтнуудын ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд мэдүүлэх ажлыг зохион байгуулж, мэдүүлгийг meduuleg.iaас.mn цахим сайтад баталгаажуулсан.
- Авлигатай тэмцэх газрын 2020.04.23-ны өдрийн 05/5036 тоот албан бичгийн дагуу АТГ-ын даргын 2018 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан журмыг баримтлан ХАСХОМ, баталгааны маягт, бүртгэлийн дэвтэр, тайлан мэдээг архивт шилжүүлж ажилласан.
- Аудиторуудаас аудитын явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн тухайд ирүүлсэн 2 мэдэгдлийг тухай бүр нь шийдвэрлэн ажилласан.
- ХАСХОМ-ын 2020 оны мэдүүлэг гаргах ажилтнуудын нэрсийн жагсаалтыг гаргаж ҮАГ-ын хүний нөөцийн ажилтанд эйбл системээр хүргүүлсэн.

Цаг үеийн шинжтэй гүйцэтгэсэн нэмэлт ажлууд



- МУЕА-ын баталсан ерөнхий чиглэлийг аудитын үе шатны ажлуудад баримтлан ажиллаж, хамрах хүрээний асуудлуудад нийт 2029 горим, сорилыг хэрэгжүүлэн 309.8 сая төгрөгийн 112 алдаа зөрчил илэрснийг аудитын тайланд тусган дүгнэлт, зөвлөмж өгч ажилласан. Ерөнхий чиглэлийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажлын тайланг нэгтгэн гаргаж хүргүүлсэн.
- МУЕА-ын 01 тоот албан даалгаврыг танилцуулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах дотоод арга хэмжээний хөтөлбөр гаргасан. Хөтөлбөрийн дагуу тайлант хугацаанд хийгдэх, ТАБ-ын 2020-2021 оны санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн өмнөх үе шатны ажлуудыг “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-д заасны дагуу гүйцэтгэн хамрагдах байгууллага, аудит хийх хэлбэрийг сонгон СУГ-т хүргүүлсэн.
- МУЕА-ын баталсан ТАБ-аас 2020-2021 оны СТА-д баримтлах ерөнхий чиглэлийн хэрэгжилтийг гаргаж, тайланг дараа онд хэрэгжүүлэх чиглэлд тусгуулах саналын хамт МУЕА-т хүргүүлсэн.
- ТАБ-ын хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх журмын төсөлд санал өгөх ажлыг зохион байгуулж, саналыг 05 дугаар сарын 26-ны өдөр ХШҮДАГ-ын ахлах шинжээч Ц.Баярмаад цахимаар хүргүүлсэн.
- ТАБ-ын дотоод аудитын журмын төсөлд санал өгөх ажлыг зохион байгуулж, саналыг 05 дугаар сарын 26-ны өдөр ХШҮДАГ-ын ахлах шинжээч Ц.Баярмаад цахимаар хүргүүлсэн.

- Орон нутгийн сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчдийн хандивын тайланг баталгаажуулах зааврын төсөлд санал өгөх ажлыг зохион байгуулж, саналыг 05 дугаар сарын 26-ны өдөр НАГ-т цахимаар хүргүүлсэн.
- Орон нутгийн сонгуульд оролцох нам, нэр дэвшигчдийн зардлын дээд хэмжээг тогтоох аргачлалын төсөлд санал өгөх ажлыг зохион байгуулж, саналыг 05 дугаар сарын 29-ний өдөр НАГ-т цахимаар хүргүүлсэн.
- Орон нутгийн сонгуульд оролцох нам, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах аргачлалын төсөлд санал өгөх ажлыг зохион байгуулж, саналыг 06 дугаар сарын 22-ны өдөр НАГ-т хүргүүлсэн.
- Аудитын тайлангийн чанарыг сайжруулж брэндбүүкт нийцүүлэн төрөлжүүлэх ажлыг үр дүнтэй хийсэн. Мөн газрын 2020 оны үйл ажиллагааны хагас жилийн тайланг ТАБ-ын 2019 оны үйл ажиллагааны тайлангийн загвараас санаа авч шинэлэг байдлаар иргэд олон нийт уншиж танилцахад ойлгомжтой жендерийн мэдрэмжтэй боловсруулж, тайлагнах ажлыг амжилттай зохион байгуулсан.
- “Ковид-19”-ын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын үед хэрэгжүүлэх 11 заалт бүхий ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг долоо хоногийн “Пүрэв” гарагт гаргаж ҮАГ-ын тамгын газрын дарга Ц.Ганболдод хүргүүлж ажилласан.
- ҮАГ-аас цахимаар зохион байгуулсан чиг үүргийн талаарх судалгаа, санал асуулгад нийт албан хаагчид бүрэн хамрагдсан.
- ТАБ-ын хэмжээнд хийгдсэн орон тоо нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагын талаарх судалгаанд оролцож, уг асуудлаар хүргүүлж байсан саналуудыг нэгтгэн 7 дугаар сард ҮАГ-ын Тамгын газрын дарга Ц.Ганболдод албан бичгээр хүргүүлсэн.
- Захиргааны ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгөх ажлыг зохион байгуулж, нийт ажилтнуудаас ирүүлсэн саналыг нэгтгэн 9 дүгээр сард ҮАГ-т хүргүүлсэн.
- ҮАГ-ын Тамгын газраас ирүүлсэн “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын төсөлд саналыг 9 дүгээр сард хүргүүлсэн.
- Акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах 21 хоногийн аяныг зохион байгуулж аудиторуудыг арга зүйгээр ханган ажилласан.
- Газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг төсөл байдлаар боловсруулж ҮАГ-ын Стратеги удирдлагын газарт 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдөр цахимаар хүргүүлсэн.
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн 518 дугаар тогтоолын дагуу газрын өмчлөлд байсан “Старекс 01-56 ДОР” автомашины ашиглалтын хугацаа дуусаж, актлагдсантай холбогдуулан нээлттэй дуудлага худалдаагаар худалдах тухай зарыг ТВ болон фейсбүүк хуудаст байршуулж ажиллалаа.

Мэдээллийн технологи



ТАБ-ын МТ-ийн бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх ажлыг зохион байгуулж, нийт ажилтнуудаас гарсан саналуудыг нэгтгэн хэлэлцэж агуулгыг сайжруулах 2, утга найруулгыг засах 5 өөрчлөлтийн саналыг СУГ-ын төслийн менежерт хүргүүлсэн.

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлж, нэвтрүүлэх үндсэн хэрэгцээ шаардлага, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох зорилгоор 2020 оны 1-р улиралд зохион байгуулсан “Дижитал аудит 2025” цахим судалгаанд байгууллагаараа идэвхтэй оролцох ажлыг зохион байгуулж, аудитор бүр өөрийн эрхээр цахим санд нэвтрэн санал өгч ажилласан.

Байгууллагын сервер, сүлжээ, компьютерын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хүрээнд дараа ажлуудыг хийлээ.

- ҮАГ-аас нэгдсэн системийн хэмжээнд ашиглаж буй Kaspersky вирусийн эсрэг программын лицензийн сунгалтад хяналт тавьж ажилласан.
- Байгууллагын нийт 12 ажилтнуудын компьютерт үг үсгийн алдаа хянагч Болор дуран программыг суулгасан.
- Байгууллагын ажилтнуудын дотоод сүлжээний хэвийн ажиллагааг ханган, 14 хоног тутамд, нийт 32 удаа хяналт тавин, сүлжээ доголдох, тоног төхөөрөмж хэвийн үйл ажиллагаа алдагдах зэрэг илэрсэн асуудлуудыг цаг тухай бүрд нь бүрэн шийдвэрлэж ажилласан.
- Онлайн хурлын тоног төхөөрөмжийн бэлэн байдлын хангаж ажиллаж байна.
- Сүлжээний аюулгүй байдлыг хангах зорилгоор ҮАГ-аас ирүүлсэн вирусын эсрэг “Эсэт” программыг албан хаагчдын компьютерт бүрэн суулгасан.
- Дорнод аймаг дахь ТЕГ-ын мэдээллийн технологийн аюулгүй байдлын талаарх судалгааг ирүүлсэн маягтын дагуу гарган хүргүүлсэн.
- ҮАГ-аас ирүүлсэн сүлжээний firewall төхөөрөмж Fortinet-ийг суурилуулсан.
- Байгууллагын бүх компьютерыг форматалж win10 үйлдлийн системд жигдрүүлж, домэйн холбож дууссан.
- ҮАГ-аас хэрэгжүүлж буй Microsoft teams программыг нийт албан хаагчид гар утсандаа болон компьютертээ суулгаж ашиглаж байна.
- Онцгой нөхцөл байдлын үед гэрээсээ онлайн орчинд ажиллах боломжийг бүрдүүлэх үүднээс “google” flatform ашиглан “glassroom, meeting”-ээр 7 хоног бүр цахим хурал хийж, хийсэн ажил, өгсөн чиглэлүүдээ “drive”-аар хурдан шуурхай солилцож ажилласан нь үнэхээр хялбар шийдэл болж гэрээсээ ажиллаж болох юм байна гэдэг дүгнэлтэд хүрцгээсэн.

Үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн шинэлэг ажлууд

Бүтээлч байдал гэж: Шинэ хэрэг болох санааг гаргах аливаа үйлдлийг хэлдэг бол инновац гэж тэрхүү шинэ санааг нь ажил хэрэг болгон зохион байгуулахыг хэлдэг байна. Тэгэхээр цоо шинээр урьдын асуудлыг харж, шинэ шийдэл гаргалгаа санаачилга гаргах бүтээлч байдал нь инновацын эхэн шат болно. Бүтээлч байдал гэдэг нь хэвшил болсон дүрэм журамд баригдахгүй өөрийнхөөрөө бодож сэтгэх эрх чөлөөнөөс эхтэй. (Robert B.Denhardt et.al.2016) гэсэн онолыг удирдлага болгон ажиллалаа.

Хийж хэрэгжүүлсэн зарим шинэлэг ажлуудаас дурдвал:

1. Төрийн аудитын тухай хуулиар хүлээсэн “Төсвийн төсөлд санал дүгнэлт өгөх” үндсэн чиг үүргийн ажлыг Төрийн аудитын байгууллагын 2019-2024

оны стратегийн 2.2.4. дэх “Харилцагч талуудын үр ашигтай хамтын ажиллагааг дэмжиж, аудитын чанар, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг дээшлүүлэх” зорилтын хүрээнд үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бүтээлчээр хандан **инновацыг хийлээ**. Өмнөх жилүүдэд төсвийн төсөл хэлэлцэх Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанд төсвийн орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах, үр ашиг сайжруулах төсөл хөтөлбөрийн жагсаалтыг мөнгөн дүнгийн хамт танилцуулдаг байсныг аудитын **тайлангийн агуулга бүхий цогц дүгнэлт болгон танилцууллаа**. Ингэснээр ИТХ-ын төлөөлөгчдөд төсвийн төсөлд өгсөн хууль, журамд нийцүүлэх саналыг тусган батлаагүйгээс төсвийн жилийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ямар эрсдэл, сөрөг үр дагавар гардаг, энэ нь жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлттэй хэрхэн холбогддог талаар ойлголтыг өгснөөр **бидний өгсөн саналыг бүрэн тусгаж 2021 оны төсвийг баталсан** дэвшилттэй үр дүнд хүрлээ.

2. Албан хаагчдын **бүтээмжийг дээшлүүлэх** зорилгын хүрээнд албан хаагчдаар өдөр бүрийн ажлын байрны зураглалыг хөтлүүлэн, түүнд нь тухайн албан хаагчийн нийт гүйцэтгэсэн ажил дахь үндсэн чиг үүргийн, туслах чиг үүргийн чиг үүргийн бус ажилд зарцуулж буй хугацаа болон тухайн ажлуудад ур чадвар шаардагдах байдлыг үнэллээ.

Түүнчлэн тухайн ажлууд нь эрхэм зорилгод нийцэх байдалд маш чухал, дэмжих, туслах шинж чанартай байгаа эсэхийг үнэлэн цагийг тооцож өөрсдөд нь танилцуулах **ажлыг санаачлан зохион байгууллаа**. Ингэснээр албан хаагчид цаашид эрхэм зорилгод маш чухал болон үндсэн чиг үүргийн ажлыг нэмэгдүүлж, ур чадвар шаардахгүй ажлыг нь багасгах, өөр албан хаагчид хуваарилах замаар менежмент хийвэл ажлын бүтээмж, үр дүн хангалттай сайн болохоор байна гэсэн **нэгдсэн нэг дүгнэлтэд хүрч чадлаа**.

Мөн ажлын бүтээмж хангалтгүй байгаа **албан хаагчийн төрөлжсөн аудитын албыг солих, ажил үүргийн хуваарилалтыг өөрчлөх** санал санаачилгыг хэрэгжүүлсэн. Энэхүү арга нь цар тахлын үед албан хаагчид гэрээсээ онлайн орчинд ажиллаж байх үед **ажлын цагийн ашиглалт, үндсэн үйл ажиллагаагаа цаг хугацаанд нь хурдан шуурхай гүйцэтгэн ажиллахад** эерэг үр дүнгээ өгсөн.

3. Онцгой нөхцөл байдлын үед гэрээсээ онлайн орчинд ажиллах боломжийг бүрдүүлэх үүднээс **“google” platform** ашиглан **“glassroom, meeting”-ээр 7 хоног бүр цахим хурал** хийж, хийсэн ажил, өгсөн чиглэлүүдээ **“drive”-аар хурдан шуурхай солилцож** ажилласан нь үнэхээр хялбар шийдэл болж гэрээсээ ажиллаж болох юм байна гэдэг дүгнэлтэд хүрцгээсэн.
4. Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны Стратегийн 4.14 дэх “Харилцагч талуудын эргэх холбоо бүхий, үр дүнтэй харилцаа бий болж, иргэд аудитын үйл ажиллагаанд оролцдог болсон байна” гэсэн зорилгын хүрээнд хөрөнгө оруулалтын аудитын дүнгээс **инфо график** бэлтгэж аймгийн ИТХ-д хүргүүлж, фейсбүүк хуудсаар **олон нийтэд түгээх** ажлыг санаачлан зохион байгууллаа. Мөн Төрийн аудитын тухай хуулийн **шинэчилсэн найруулгыг түгээн таниулах** зорилгоор Үндсэн хууль, бусад хуультай хэрхэн холбогддог талаар мэдээлэл бэлтгэн төсөвт байгууллагын **нийт санхүүгийн ажилтнууд болон орон нутгийн телевизэд мэдээлэл танилцуулгыг хийсэн**. Сумдад томилолтоор ажиллахдаа дээрх мэдээллийг түгээх ажлыг давхар зохион байгуулж ажилласнаар энэ

жилийн хувьд шалгагдагч байгууллагууд акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг заасан хугацаанд, шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, аудитын тайлагналын дараах ажлын үр дүнг нэмэгдүүллээ.

5. Дээрх зорилгын хүрээнд аудитын тайлангийн чанарыг сайжруулж брендбүүкт нийцүүлэн **төрөлжүүлэх** ажлыг үр дүнтэй хийсэн. Мөн **газрын 2020 оны үйл ажиллагааны хагас жилийн тайланг** ТАБ-ын 2019 оны үйл ажиллагааны тайлангийн загвараас санаа авч шинэлэг байдлаар иргэд олон нийт уншиж танилцахад ойлгомжтой **жендерийн мэдрэмжтэй** боловсруулж, тайлагнах ажлыг амжилттай зохион байгуулсан.
6. Захиргааны ерөнхий хуулиар заасан процедурын үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлэх зорилгоор сумдад аудитын үйл ажиллагааг гүйцэтгэхдээ аудитын төлөвлөгөө, удирдамжтай танилцсан тухай **загвар хүснэгт гаргаж** танилцсан албан тушаалтнуудаар гарын үсэг зуруулдаг болсон. Мөн аудитын үйл ажиллагааг сурталчлан таниулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аудитын төлөвлөгөө, үр дүн, цаашид анхаарах асуудлын талаар сумдын төрийн байгууллагуудын удирдлага, санхүүгийн ажилтнууд, **иргэдэд танилцуулга хийх**, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулсан. Ингэснээр харилцагч байгууллага, иргэдээс аудитын бус хугацаанд зөвлөгөө, **мэдээлэл авах байдал нэмэгдэж харилцан ойлголцох, эргэх холбоо** бүхий үр дүнтэй харилцаа бий болж байна.
7. Аудитын үр дүнд иргэдийн амьдрал сайжирсан байх ёстой гэсэн эрхэм зорилгын хүрээнд **иргэдийн хүлээлттэй байгаа сэдвээр** аудит хийх зорилгоор аудитын сэдвийг сонгохдоо иргэдээс **googleform, фэйсбүүк** ашиглаж санал асуулгыг цахим хэлбэрээр мөн **байгууллагад санал хүсэлтээ ирүүлэх** гэсэн олон сонголтоор зохион байгуулсан.
8. СТА-ын үе дэх ачааллыг буруулах зорилгоор санхүүгийн тайлангийн аудитад хараат бус аудитын компанийн оролцоог 2020 онд нэмэгдүүлэн ажиллалаа. Ингэхдээ **аудит хийх багийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон эрүүл мэнд, боловсролын салбарт 10-аас дээш жил ажилласан, аудиторын эрхтэй, мэргэшсэн нягтлан бодогчоор бүрдүүлсэн давуу талыг нь харгалзан шалгаруулснаар** аудитын чанарт дэвшил гарсан.
9. Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд хууль зөрчсөн аливаа үйлдлийг таслан зогсоох, тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд хамтран ажиллах **санамж бичгийг аймгийн Прокурорын газартай байгуулж** ажилласан.

8. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ



Тус газрын 2020 оны санхүүгийн бүртгэл, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Татвар болон нийгмийн даатгалын

багц хууль, холбогдох журам зааврын дагуу аккруэль сууриар илэрхийлэн “Юникус” программаар гарган ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу тухай бүрд оруулах 96 мэдээлэл, сар бүр оруулах 36 мэдээлэл, улирал бүр оруулах 3, хагас жилээр оруулах 4, бүтэн жилээр оруулах 5 мэдээллийг цахим сайтад хуулийн хугацаанд нь байршуулж, мэдээллийн самбараар мэдээлэн ажиллалаа.

Байгууллагын шилэн дансны хэрэгжилтийг жил болгон аудитор томилон хяналт хийлгэн ирсэн. Энэ жил нийцлийн аудитын албаны аудитор М.Ухаанбилэг хяналтыг хэрэгжүүлж гарсан зөрчлийг хугацаатай албан даалгавар гарган залруулж ажилласан.

Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллаар, сар улирлын хуваарийн дагуу зарцуулж 12 дугаар сарын 15-ны байдлаар 434,320.0 мянган төгрөгийн батлагдсан төсвөөс 392,015.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь албан хаагчдын 12 дугаар сарын сүүлийн хагасын цалин, 3 болон 4-р улирлын урамшуулал олгогдоогүйтэй холбоотой болно.

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	БАТЛАГДСАН ТӨСӨВ	ГҮЙЦЭТГЭЛ
1220	Санхүүжилтийн орлого	434,320,000.00	392,015,243.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	343,883,400.00	310,152,555.94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал	46,706,800.00	38,661,412.45
2103	Байр ашиглалттай холбоотой зардал	1,448,500.00	1,448,500.00
2104	Хангамж бараа материалын зардал	11,980,000.00	11,980,000.00
2107	Томилот, зочны зардал	8,000,000.00	8,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	16,708,800.00	16,180,275.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	2,500,000.00
2132	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,092,500.00	3,092,500.00

Газрын 2019 оны санхүүгийн тайланд “Гранд торнтон аудит” ХХК-аар аудит хийлгэн зөрчилгүй санал дүгнэлт авч, өгсөн 4 зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг хүргүүлж ажиллалаа.

НД болон татварын байгууллагатай хийх тооцоог цаг хугацаанд нь гүйцэтгэн, тайланг хүргүүлж, 2020 оны санхүүгийн тайланд эхний үлдэгдлээр тусгагдсан ХХОАТ-ын 1,614.1 мянган төгрөгийн өглөгийг 2 дугаар улиралд барагдуулсан бөгөөд дахин өр, авлага үүсгээгүй.

МУЕА-ын 2018 оны А/53 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ыг үндэслэн 2020 онд шаардлага хангасан ахлах аудитор Д.Нармандах, Б.Батжаргал, аудитор Я.Зориг нарт төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгосон.

Газрын 2021 оны төсвийн төслийг боловсруулж 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр Ерөнхий аудиторын орлогч С.Бүрэнбатад, төсвийн төсөлд тусгах хөрөнгө оруулалтын саналыг ҮАГ-ын тамгын газрын дарга Ц.Ганболдод тус тус хүргүүлж ажиллалаа.

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас газрын албан хэрэгцээнд ашиглаж байгаа, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашин, тоног төхөөрөмжийг өмчлөх

эрхийг шилжүүлэх тухай тогтоол гарч тус хөрөнгүүдийг орлогоор бүртгэж авах зөвшөөрлийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт уламжлуулах ажлыг зохион байгуулан ажилласан.

Газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын тушаалаар батлагдсан комисс нь ТБОНӨТХ-ийн дагуу байгууллагын өмч хөрөнгийн тооллогыг хагас жилээр зохион байгуулж, дүнг баталгаажуулан ҮАГ-т хүргүүлж, үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Hyundai Starex маркийн автомашиныг данснаас хасуулах хүсэлтийг Ерөнхий аудиторын орлогч С.Бүрэнбатад хүргүүлж шийдвэрлүүлсэн.

Газрын төсвийн зарцуулалтын сар, улирлын мэдээг хугацаанд нь гарган, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг аймгийн төрийн сангаар баталгаажуулж ерөнхий санхүүч О.Оюунсайханд албан мэйлээр хүргүүлэн ажилласан.

9. ДҮГНЭЛТ, ЦААШДЫН ЗОРИЛТ

Дорнод аймаг дахь ТАГ нь ТАБ-ын хэмжээнд дэвшүүлсэн “Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн жил”-ийн зорилтын хүрээнд шинэчлэгдэн батлагдсан Төрийн аудитын тухай хууль, шинээр батлагдсан Төрийн аудитын Монгол Улсын стандартыг судлан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.

Газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ТАБ-ын 2019-2024 оны стратегийн зорилтуудад нийцүүлэн 5 чиглэлийн хүрээнд 63 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажиллалаа. Үүнээс аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүнг нийтэд мэдээлэх нийцлийн аудитын 1 ажлын дуусах хуулийн хугацаа болоогүй байна.

ТАБ-ын орон нутаг дахь байгууллагуудын төлөвлөгөөнд ҮАГ-ын нэгдсэн зохион байгуулалтаар хийгдэхээр тусгагдсан журам, гарын авлага, хөтөлбөрийн төслүүдэд санал өгөх 7 арга хэмжээний зохион байгуулалтын ажил хийгдээгүй тул 2021 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шилжүүллээ.

Батлагдсан сэдвийн хүрээнд гүйцэтгэсэн төлөвлөгөөт аудитуудыг стандартын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэхэд анхаарч, чанарын хяналтыг үе шат бүрээр хэрэгжүүлэн 3 төрлөөр нийт 176 аудитыг гүйцэтгэсэн нь 11,831.4 сая төгрөгийн үр өгөөжийг шалгагдагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж төсвөөс авсан санхүүжилтийн 1 төгрөг тутамд 30.2 төгрөгийн үр өгөөжийг бий болгосон байна.

Төрийн аудитын дээд байгууллага болох ҮАГ-аас санхүүгийн тайлангийн аудитад хэрэгжүүлэх ерөнхий чиглэлийг МУЕА-аар батлуулан, хэрэгжүүлэх арга зүйг дэлгэрэнгүй гарган ирүүлсэн нь аудитын чанарыг сайжруулах, орон нутаг дахь аудитын газрууд нэг бодлого, нэг арга зүйгээр аудитыг гүйцэтгэж, илэрсэн асуудлыг адил түвшинд шийдвэрлэх байдалд түлхэц боллоо.

Өөрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг сайжруулахын тулд хөрөнгө, санхүү болон хүний нөөцийг зөв зохистой удирдаж, өмнө нь хийж байсан аудитын болон дотоод зохион байгуулалтын ажлуудыг шинэ санаа, бүтээлч хандлагаар шинэлэг хэлбэрээр хийхээр зорьж ажилласан нь тодорхой үр дүнд хүрч цаашдын ажилд урам өглөө.

Дэлхий нийтийн өмнө тулгарсан цар тахлын нөхцөл байдалд ажилтнуудын ажиллах нөхцөлийг ханган, ажлын чанар үр дүнг бууруулахгүй байх талаар ТАБ-ын удирдлагаас өгсөн чиглэлийг онцгой анхаарч технологийн дэвшлийг ашиглан цахим орчинд ажиллах туршилтыг хамт олноороо амжилттай хэрэгжүүллээ.

Цаашид ТАБ-ын үйл ажиллагааг иргэд, олон нийтийн дунд сурталчлах, таниулах, суралцагч байгууллага, суралцагч хамт олон байх, салбарын хэмжээнд манлайлагч байх зорилтуудыг тавин хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР